



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А1663

Хэрлэн сум

Уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр “Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүд болон сумдын Засаг дарга нарын хамтарсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад 4,284,000 (дөрвөн сая хоёр зуун наян дөрвөн мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 19-ний өдрийн
А.1663 дугаар захирамжийн хавсралт

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ГАРСАН ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр, төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Дүн
1.	Өдрийн хоол	40 хүн	43,150т	1,726,000т
2.	Оройн хоол	40 хүн	63,950т	2,558,000
Нийт дүн				4.284.000т